



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/679

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2022 оны 152 дугаар захирамж, Батлан хамгаалахын сайд, Төв аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол цэргийн нэгдсэн холбоо, Монгол хурандаа нийгэмлэгээс зохион байгуулах, хүүхэд залуучуудад эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, Эх орноороо бахархах, хайрлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлан дэлгэрүүлэх, Ахмад үеийн хөдөлмөрч, дайчин замнал, үнэт өвийг үе дамжуулан үлдээх, залуу хойч үеийнхэнд заан сургах, өвлүүлэн үлдээх зорилгоор “БИДНИЙ БАХАРХАЛ” төслийг сум орон нутагт хэрэгжүүлэн ажилласугай.

2. “БИДНИЙ БАХАРХАЛ” арга хэмжээг зохион байгуулах байр, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Монгол туургатан театрын дарга (Д.Намсрайноров) Зуунмод, Батсүмбэр, Борнуур, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хариуцуулсугай.

3. Төв аймгийн Политехникийн коллежийн оюутнууд, Сум орон нутгийн ахлах ангийн “8-12 дугаар анги” сурагчдыг төслийн арга хэмжээнд хамруулж ажиллахыг Зуунмод Сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч (Ч.Сарангэрэл) Батсүмбэр сумын Засаг дарга (Д.Ганболд) Борнуур сумын Засаг дарга (Н.Ундрахбилэг) Жаргалант сумын Засаг дарга (Н.Энхболд) Төв аймгийн Политехникийн коллежийн захирал (Б.Жаргалмаа) нарт үүрэг болгосугай.

4. Нэгтгэл, анги, байгууллагын үйл ажиллагааг хүүхэд залуучуудад сурталчлан, анги байгууллагын онцлогийг илэрхийлсэн үзэсгэлэн гаргаж ажиллахыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч хурандаа (Ж.Мөнхбаяр) Онцгой байдлын газрын дарга хурандаа (Н.Төмөрбаатар) Цагдаагийн газрын дарга дэд хурандаа (Ч.Алтанхуяг) нарт хариуцуулсугай.

5. Төслийн гишүүдийг ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллахыг Цэргийн штабын дарга дэд хурандаа (Т.Төмөрчөдөр) Төв аймаг дахь Монгол цэргийн салбар хорооны нарийн бичгийн дарга (С.Очирбат) нарт даалгасугай.

6. Уг арга хэмжээнд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

7. Арга хэмжээнд зарцуулагдах 1,132,640 (нэг сая нэг зуун гучин хоёр мянга зургаан зуун дөч) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

